



**ЗАМ, ТЭЭВРИЙН  
ЯАМ**

**САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ  
2025 он**



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2026.02.09

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго**

Зам, тээврийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг үндэслэл болгосон.

**Хоёр. Танилцуулга**

Зам, тээврийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын 2025 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайдын тушаалын биелэлт, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт гэсэн 6 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 96.0 хувьтай байна.

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

*Хүснэгт №1*

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь	Жинлэсэн хувь
1.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	-	-	-
2.	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	-	-	-
3.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	16	93.1	18.62

4.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	38	97.0	19.4
5.	Сайдын тушаалын хэрэгжилт	3	100.0	10
6.	Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт	97	97.9	9.79
7.	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	12	95.0	9.5
8.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	147	95.2	9.52
9.	Зам, тээврийн сайдын аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээ, "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт	-	-	-
10.	Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	-	-	-
<b>Нийт</b>			<b>96.4</b>	<b>96.0</b>

**2.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:**

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд харуулав.

*Хүснэгт №2*

Нийт заалт	Үүнээс:						Хугацаа болоогүй	Биелэлт (хувиар)
	100%	90%	70%	50%	30%	0%		
<b>16</b>	<b>9</b>	<b>5</b>	<b>2</b>	-	-	-	-	<b>93.1</b>

Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Зам, тээврийн яамны зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулсантай холбоотойгоор 2025 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр Санхүү, хөрөнгө оруулалтын газар 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан ажилласан байна. Төлөвлөгөөнд туссан нийт 16 арга хэмжээнээс 100 хувийн биелэлттэй 9 арга хэмжээ, 90 хувийн биелэлттэй 5 арга хэмжээ, 70 хувийн биелэлттэй 2 арга хэмжээ байгаа бөгөөд хэрэгжилтийн дундаж үнэлгээ 93.1 хувьтай байна.

*Хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ:*

*Хүснэгт №3*

№	Арга хэмжээний заалт, агуулга	Зорилтот түвшин	Хугацаа	Биелэлт	Хувь
1.	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг хангах, тайлагнана.	Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан шинэ эхлэх 15 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулна. 2025 онд хэрэгжүүлэхээр	I-IV улирал	2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 02 дугаар хавсралтаар батлагдсан Зам, тээврийн сайдын төсвийн хөрөнгөөр 2025 онд шинээр батлагдсан 15 төсөл арга хэмжээний	70

		<p>батлуулсан шинэ төсөл арга хэмжээний хэрэгжилтийг 2025 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 85 хувиас дээш биелүүлсэн байна. Сайдын багцын 2024 оны жилийн эцсийн худалдан авах ажиллагааны тайлан, мэдээг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж тайлагнана.</p> <p><b>III-IV улирал:</b></p> <p>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 85-аас доошгүй хувийн хэрэгжилттэй байна.</p>		<p>худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 233 дугаар тогтоолын дагуу боловсруулж Зам, тээврийн сайдын 2024 оны А/294 дүгээр “Төлөвлөгөө батлах тухай” тушаалыг батлуулсан.</p> <p>Мөн Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг гадаад, дотоод хүчин зүйлстэй холбогдуудан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд шаардлагатай өөрчлөлтүүдийг тухай бүрт нь боловсруулж Зам, тээврийн сайдын А/73 дугаар “Тушаалын хавсралтад нэмэлт оруулах тухай”, А/102 дугаар “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, А/314 дүгээр “Тушаалд нэмэлт оруулах тухай” тушаалуудыг тус тус боловсруулан батлуулсан.</p> <p>Сайдын багцын 2024 оны жилийн эцсийн худалдан авах ажиллагааны тайлан, мэдээг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор худалдан авах ажиллагааны цахим систем болон, шилэн дансны цахим системд боловсруулж хүргүүлсэн.</p> <p>2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт тендер зарласанаар 85%, гэрээ байгуулснаар 72% гүйцэтгэлтэй байна.</p>	
2.	<p>Улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянан баталгаажуулж санхүүжилтийн хуваарийн дагуу санхүүжилтийн эрх нээлгүүлж, санхүүжүүлнэ.</p>	<p>Улсын төсвийн хөрөнгөө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээгээр компани тус бүртэй тооцоо нийлж, үлдэгдлийн баталгаа гаргаж, санхүүгийн тайланд тайлагнана. МУ-ын 2025 оны төсвийн тухай хуулиар хөрөнгөө оруулалтын зардалд 97 төсөл арга хэмжээнд 951,2 тэрбум төгрөг батлагдсанаас, барилга байгууламж, их засварын ажил</p>	I-IV улирал	<p>МУ-ын 2025 оны төсвийн тухай хуулиар хөрөнгөө оруулалтын зардалд 95 төсөл арга хэмжээнд 918.1 тэрбум төгрөг батлагдсанаас, барилга байгууламж, их засварын ажил гүйцэтгэхээр шалгарч гэрээ байгуулсан аж ахуйн нэгжид ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолын дагуу гүйцэтгэлийг хянаж, 602.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож 65.6 хувийн биелэлттэй байна.</p>	70

	<p>гүйцэтгэхээр шалгарч гэрээ байгуулсан аж ахуйн нэгжид ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолын дагуу хянаж, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд баримтын иж бүрдлийг ханган илгээж, санхүүжилтийг өмнөх оноос бууруулахгүй олгосон байна. Гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэлийг хянан эрх нээлгүүлж, санхүүжилтийг 87% хүргэж санхүүжүүлэх, ил тод байдлыг хангах, бүх түвшинд мэдээллээр хангана.</p>		<p>Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2025 онд Зам, тээврийн салбарын хэмжээнд хэрэгжүүлэхээр нийт 35 төсөл арга хэмжээнд 158.4 тэрбум төгрөгийг Сангийн сайдын багцад баталсан ба барилга байгууламж, зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэхээр шалгарч гэрээ байгуулсан аж ахуйн нэгжид нийт 24.15 сая долларын болон 14.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож 67 хувийн биелэлттэй байна.</p>	
--	---	--	--	--

## 2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэвэл:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр тус газарт 39 үүрэг даалгавар өгөгдсөнөөс бүрэн хэрэгжсэн 31, хэрэгжих шатанд 3, хугацаа болоогүй 3, хэрэгжих боломжгүй 2 арга хэмжээний дундаж үнэлгээ 97.0 хувьтай байна. Хэрэгжилтийг Хүснэгт №4-д харуулав.

Хүснэгт №4

Нийт заалт	Үүнээс:					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэг жээгүй	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
38	31	2	-	3	2	97.0

1. Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай.

2023-04-25 Дугаар 2023 № 05 ТБХ

Заалт: За/. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, өмч хөрөнгийн бүртгэл, хэрэгжилт, үр дүнд тавих хяналтыг сайжруулах, хэрэгжиж дууссан төслүүдийн хүрээнд үүссэн өмч, хөрөнгийн бүртгэлийг судлах, зээлийн эргэн төлөлтийн байдал, шинээр авахаар төлөвлөж буй зээлүүдийн эрэлт хэрэгцээг үнэлж, дүн шинжилгээ хийх, үр дүн муутай, хэрэгжилт удаашралтай төслүүд болон шинээр авахаар төлөвлөж буй шаардлагагүй гэж үзсэн зээлийг зогсоох, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг салбар бүрээр гаргах, танилцуулах;

Биелэлт: 2020-2021 онд авсан ОУ санхүүгийн байгууллагуудаас авсан зээлүүдийн тоног төхөөрөмжийн шинж чанартай зээлүүдийг судалж Сангийн яамтай дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулах, өмч хөрөнгийг орлогод авах ажлыг ТӨБЗГ-т хүсэлт тавиад байна.

2. Төсөл, хөтөлбөрийн жагсаалт батлах тухай  
2023-08-23 Дугаар 2023\_323

Заалт: 2. Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Азийн хөгжлийн банктай тохиролцож, холбогдох гэрээ, хэлэлцээрийг байгуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд, төсөл, хөтөлбөрийг цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд тус тус даалгасугай.

Биелэлт: Тогтоолын хавсралтад заасан "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх засвар арчлалтын төсөл (III үе шат)"-ийн зээлийн хэлэлцээрийг Азийн хөгжлийн банктай байгуулж УИХ-аар соёрхон батлуулсан. Зээлийн хэлэлцээрийн дагуу төслийн зөвлөх болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил ЗТЯ болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт явагдаж байна.

### 2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Сайдын тушаалаар Санхүү, хөрөнгө оруулалтын газарт өгөгдсөн 3 үүрэг даалгавар бүрэн хэрэгжиж, 100 хувийн үнэлгээтэй байна. Хэрэгжилтийг Хүснэгт №5-д харуулав.

Хүснэгт №5

Нийт заалт	Үүнээс:					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэг жээгүй	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
3	3	-	-	-	-	100

### 2.4. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар Санхүү, хөрөнгө оруулалтын газарт өгөгдсөн 97 үүрэг даалгавраас 93 үүрэг даалгавар бүрэн хэрэгжиж, 4 үүрэг, даалгавар хэрэгжих шатанд байна. Үзүүлэлтийг Хүснэгт №6-д харуулав.

Хүснэгт №6

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэг жээгүй	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
97	93	4	-	-	-	97.9

### 2.5. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээ:

Тус газраас Нийтийн мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг 12 үзүүлэлтээр тайлагнаж ажилласан байна. Үүнээс 10 шалгуур үзүүлэлтийн үнэлгээ 100 хувьтай, 2 шалгуур үзүүлэлт 70 хувьтай үнэлэгдсэн байна. Үнэлгээг Хүснэгт №7-д харуулав.

*Хүснэгт №7*

д/д	Бүлгийн нэр	Үнэлгээний хувь					Дундаж хувь
		100	70	30	0	Хамааралгүй	
1.	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	-	-	-	-	-	-
2.	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	-	-	-	-	-	-
3.	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	10	2	-	-	-	95.0
4.	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал	-	-	-	-	-	-
5.	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	-	-	-	-	-	-
<b>Нийт дундаж</b>		<b>10</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>95.0</b>

## Гурав. Үнэлэлт, дүгнэлт

### 3.1. Төлөвлөлтийн байдал:

3.1.1. Санхүү, хөрөнгө оруулалтын газрын үйл ажиллагааны онцлог нь тогтмол байнгын давтагдах шинжтэй байдаг. 2025 онд тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 16 арга хэмжээг төлөвлөсөн байна.

3.1.2. Тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт нь тодорхой, хэмжигдэхүйц, ач холбогдолтой, үр ашигтай, зохистой, хяналт тавихуйц байх шаардлагыг хангаж чадахгүй байна.

3.1.3. Шалгуур үзүүлэлт нь зорилттойгоо уялдаж чадахгүй байна.

### 3.2. Хэрэгжилтийн байдал:

3.2.1. Зам, тээврийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын 2025 оны жилийн эцсийн үйл ажиллагааг Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээ гэсэн 6 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 96.0 хувиар үнэлэгдсэн байна.

3.2.2. Тус газраас 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 16 арга хэмжээний хэрэгжилт 93.1 хувь байна. Үүнээс 87.5 хувь нь хангалттай буюу бүрэн хангалттай, 12.5 хувь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна.



---

**Дөрөв. Санал, зөвлөмж**

4.1. Санхүү, хөрөнгө оруулалтын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээний зорилтот түвшнийг хэмжихдээ аль болох тоон шалгуур үзүүлэлтээр илэрхийлэх,

4.2. Шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшний уялдааг хангах,

4.3. 2026 оны төлөвлөгөөнд Эрсдэлийн удирдлага, байгаль орчныг хамгаалах талаар арга хэмжээ нэмж оруулах,

4.4. Газрын төлөвлөгөөнд туссан арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж ажиллахад анхаарахыг албан хаагчдад зөвлөж байна.

СХШУДАГ